



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2013 онд 04 сарын 16 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Тус газрын дүрмийн 2.3, 3.2.1, 3.2.2, 3.2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1."Нийслэлийн аялал жуулчлалын газрын мэдээллийн байгууламжийг ашиглах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг маркетинг сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Б.Халиунд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧИЙН



Э.БАТТУЛГА



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Нийслэлийн Аялал жуулчлалын газар /цаашид "газар" гэх/-ын мэдлийн Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байрлалтай мэдээллийн самбар /цаашид "мэдээллийн байгууламж" гэх/-ыг түр хугацаагаар ашиглах, түүгээр дамжуулан мэдээлэл түгээх үед Нийслэлийн аялал жуулчлалын газар, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2 Энэхүү журам нь Монгол улсын Үндсэн хууль, Зар сурталчилгааны тухай хууль болон бусад хууль тогтоомжид үндэслэнэ

Хоёр. Ерөнхий зүйл.

- 2.1 Мэдээллийн байгууламжийг нийслэлийн аялал жуулчлалын хөгжилд зэрэг нөлөөтэй аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, шинэлэг үйлчилгээ, жуулчдад зориулсан урлаг соёл, спортын арга хэмжээний мэдээллийг түгээх зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагуудад үнэ төлбөргүй ашиглуулна.
- 2.2 Газарт бичгээр тавьсан хүсэлт, бүтээгдэхүүн, үйлчилгээний тайлбар, мэдээллийн загвар, дизайн, агуулгыг харгалзан мэдээллийн байгууламжийг түр хугацаагаар ашиглах зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.
- 2.3 Газрын маркетинг, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн нь мэдээллийн байгууламж ашиглах гэрээ байгуулах, сунгах, цуцлах, ашиглалтын байдалд хяналт тавих ажлыг хариуцна.
- 2.4 Мэдээллийн байгууламжийн ашиглалт, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор зөвшөөрлийг дээд тал нь нэг сарын хугацаатай олгоно.

Гурав. Мэдээллийн байгууламж ашиглахад тавигдах шаардлага

- 3.1 Мэдээллийн байгууламж ашиглан олон нийтэд мэдээлэл түгээхдээ Зар сурталчилгааны тухай хууль болон бусад хууль тогтоомж, хэм хэмжээг чанд баримтална.
- 3.2 Аж ахуйн нэгж байгууллагын мэдээлэл нь Улаанбаатар хотын хөгжлийн бодлогод нийцсэн агуулгатай, загвар дизайны хувьд үзэмжтэй, үг үсэг утга найруулгын хувьд алдаагүй байна.
- 3.3 Мэдээллийн байгууламжид тавигдах мэдээллийг газартай тэрээ байгуулсан мэргэжлийн байгууллага байрлуулж, чөлөөлнө. Мэдээллийг байрлуулах, буулгах, цэвэрлэх болон мэдээлэл байрлуулах хугацаанд мэдээллийн байгууламжид учирсан эвдрэл, гэмтлийн зардлыг мэдээлэл байрлуулсан аж ахуйн нэгж, байгууллага бүрэн хариуцна.
- 3.4 Ашиглалтын хугацаа дуусахад аж ахуйн нэгж, байгууллагууд нь өөрсдийн ашигласан мэдээллийн байгууламжийг чөлөөлж цэвэрлэн газраас гаргасан ерөнхий мэдээллийг буцаан байрлуулсан байна.

Дөрөв. Зөвшөөрлийг сунгах, цуцлах

- 4.2.1 Мэдээллийн байгууламж ашиглах түр зөвшөөрлийг 1 удаа 14 хүртэлх хоногоор сунгаж болно. Сунгуулах тухай хүсэлтийг зөвшөөрлийн хугацаа дуусахаас ажлын 5 хоногийн өмнө газарт ирүүлсэн байна.
- 4.2.2 Зөвшөөрлийг сунгах, эсэх шийдвэрийг газрын дарга маркетинг, сурталчилгаа хариуцсан мэргэжилтний саналыг харгалзан гаргана.
- 4.2.3 Зөвшөөрлийг ажлын шаардлагын улмаас цуцалж, өөр мэдээлэл байрлуулсан тохиолдолд зөвшөөрлийн үлдсэн хугацаанд аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийг ижил төрлийн мэдээллийн байгууламжид байрлуулж болно.
- 4.3.1 Хууль, журам зөрчсөн тохиолдолд газрын санаачилгаар гэрээг цуцална. Зөвшөөрөл нь цуцлагдсан байгууллага, аж ахуйн нэгжид 1 жилийн дотор дахин зөвшөөрөл олгохгүй.

--ооОоо---